



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 09 сарын 19 өдөр

Дугаар 398

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн “Багануур АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн 2021 оны төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт хамгаалалт, захиран зарцуулалтын үйл ажиллагаанд хийсэн Улсын байцаагчийн баримтын шалгалтаар нийт 31 379 425 (гучин нэгэн сая гурван зуун далан есөн мянга дөрвөн зуун хорин таван) төгрөгийн зөрчил дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны А-1/66 дугаар албан даалгаврын хэрэгжилт 96.1 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэсүгэй.

2. “Багануур АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн 2021 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

3. “Багануур АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал А.Алтангадаст санхүүгийн сахилга батыг хэвшүүлэн дотоод хяналтыг сайжруулж дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай.

3.1. Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган, зөрчил дутагдлыг давтан гаргахгүй ажиллах;

3.2. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, гүйцэтгэх захиралтай байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээгээр олгосон эрхийн хүрээнд үйл ажиллагаагаа зохион байгуулах, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй зардал, хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэхгүй байх;

3.3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг болон Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөх, тайлагна журам”-ыг мөрдөж ажиллах;

3.4. Үндсэн хөрөнгөд бүртгэлгүй, үнэ өртөг тодорхойгүй, цэвэрлэгээний болон нөхөөсний зориулалттай 2 ширхэг автомашины үнийг тогтоож, бүртгэлд тусгах арга хэмжээ авах;

3.5. Шинээр олж авсан болон бүртгэлгүй газар эзэмших эрхийг үнэлж, данс бүртгэлд тусгах;

4. Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг 2022 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

132002845

5.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-г даалгасугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн
318 дугаар тогтоолын хавсралт



“Багануур АЗЗА” төрийн өмчит компанид хийсэн шалгалтаар
илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах
арга хэмжээний жагсаалт

Д/д	Зөрчил дутагдлын утга	Мөнгөн дүн /сая төгрөг/	Зөрчил дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Худалдан авалтын төлөвлөгөөнөөс гадуурх худалдан авалт болон төсөвт өртгөөс хэтрүүлэн авсан худалдан авалт	29.5	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг болон Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөж ажиллах.
2	Зөвшөөрөлгүй бэлтгэсэн үндсэн хөрөнгө	1.9	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, батлагдсан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг мөрдөж ажиллах.
3	Төв аймгийн Эрдэнэ суман дахь шуурхай ажлын хэсгийн эзэмшлийн газрын эзэмших эрхийг баталгаажуулаагүй, үнэлж бүртгэлд тусгаагүй.	-	Газрын эрхийг баталгаажуулан авах, 2022 оны санхүүгийн тайланд үнэлж, тусгах ажлыг зохион байгуулах.
4	Зам, тээврийн яамнаас 2021 онд хүлээн авсан, 2 ширхэг, УБУ-87-01, УНД-87-01 улсын дугаартай, МАЗ маркийн тээврийн хэрэгслийг үнэ тогтоон, санхүүгийн тайлан тэнцэлд тусгаагүй.	-	Үнэ, үнэлгээ тодорхойгүй, цэвэрлэгээний болон нөхөөсний зориулалттай, 2 ширхэг автомашины үнийг шинэчлэн тогтоох, бүртгэлд тусгах.
Зөрчил дутагдлын нийт дүн		31.4	(гучин нэгэн сая гурван зуун далан есөн мянга дөрвөн зуун хорин таван) төгрөг